



ХЭНТИЙ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/25

Мөрөн сум

“Дотуур байрны их засвар”-ын ажил хүлээн
авах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Сумын Засаг даргын 2026 оны 03 сарын 10-ны өдрийн А/42 тоот захирамжаар байгуулагдсан Сумын ажлын хэсгийн 2026 оны 03 сарын 30-ны өдрийн 09 тоот зөвлөмжийг тус тус үндэслэн ТУШААХ нь.

1.“КЭЙ ЭЛ СИ СИ”-ХХК нь сумын ОНХ сангийн хөрөнгө оруулалтаар “ДОТУУР БАЙРНЫ ИХ ЗАСВАР”-ын ажлын сонгон шалгаруулалтад тэнцэж 2026 оны 03 сарын 30-наас 2026 оны 08 сарын 15-ны дотор хийж гүйцэтгэхээр гэрээ байгуулсан тул уг ажлын явцад захиалагчийн зүгээс хөндлөнгийн хяналт байнга тавих, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, техникийн тодорхойлолтод заасны дагуу хүлээн авах эрх бүхий Сумын ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Ө.Өнөрөө - Нийгмийн бодлогын мэргэжилтэн

Гишүүдэд: М.Ариунаа – Сургуулийн захирал

Б.Нөхөрлөл - ЕБС-ийн Аж ахуйн нярав

А.Баяртуяа - Сургуулийн дуу хөгжмийн багш


Б.Баасандорж- Багийн засаг дарга

2.“КЭЙ ЭЛ СИ СИ”-ХХК аас хүлээн авах ” ДОТУУР БАЙРНЫ ИХ ЗАСВАР”- ын ажлыг гэрээний хавсралт болох техникийн тодорхойлолтыг үндэслэн өнгө үзэмж, тоо ширхэг, чанар байдлыг нэг бүрчлэн шалгаж, фото зургаар баримтжуулан акт үйлдэж хүлээн авахыг Ажлын хэсгийн ахлагч (Ө.Өнөрөө)-д даалгасугай.

3.Цаашдын ашиглалтад байнгын хяналт тавьж, засвар үйлчилгээг тогтмол хийж ажиллахыг ЕБС-ийн Захирал (М.Ариунаа)-д зөвлөсүгэй.

4. Дотуур байрны барилгын хуучин эд материалыг цаашид яаж ашиглах талаар санал боловсруулж Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлдөө танилцуулж шийдвэр гаргуулж ажиллахыг ЕБС-ийн Захирал (М.Ариунаа)-д зөвлөсүгэй.

ДАРГА



Н.НАМЖИЛНОРОВ